АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Архангай аймгийн Стандарт хэмжил, зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/20/-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Архангай аймаг<br>2022 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Н.Алтантуяа<br>Утас: 703333019<br>Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Аудитын санал дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................3

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................................3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................................4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................................5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........................................................6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................................7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........................................................8

3. Аудитын тайлан........................................................9

3.1 Ерөнхий зүйл........................................................9

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................10

3.4 Материаллаг байдал ........................................................10

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................................10

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................................11

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................................12

3.8 Аудитын гол асуудал ........................................................12

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ................13

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........................................................13

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................13

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................................13

4. Аудитын илрүүлэлт ........................................................14

4.1 **Залруулсан алдаа** ........................................................ 14

4.2 **Албан шаардлага** ........................................................ 14


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СХЗГ | Стандарт хэмжил зүйн газар |

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.ХҮРЭЛСҮХ ТАНАА

2022.02.11 № 01

танай ____________-ны № ____________-т

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 6,751,764.00 | 8,665,722.33 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6,751,764.00 | 8,665,722.33 |
| 35100 | Түүхий эд материал | 52,000.00 | 122,000.00 |
| 35130 | Эм боох материал | 52,000.00 | 122,000.00 |
| 35400 | Хангамжийн материал | 6,699,764.00 | 8,543,722.33 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,953,795.00 | 1,394,340.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,470,869.00 | 5,543,382.33 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 9,000.00 | 9,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 266,100.00 | 1,597,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 235,500,762.99 | 216,390,325.35 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 235,500,762.99 | 216,390,325.35 |
| 39200 | Биет хөрөнгө | 194,360,762.99 | 175,250,325.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 128,011,400.00 | 128,011,400.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -9,890,247.42 | -16,483,745.70 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 17,900,000.00 | 17,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -17,900,000.00 | -17,900,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 73,670,400.96 | 73,670,400.96 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -32,568,092.77 | -41,007,272.65 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,321,197.50 | 9,921,197.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,833,026.89 | -7,473,472.65 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 57,964,683.05 | 57,964,683.05 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -30,836,902.44 | -34,874,216.16 |
| 39217 | Ном | 5,521,351.00 | 5,521,351.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 41,140,000.00 | 41,140,000.00 |
| 39301 | Програм хангамж | 775,000.00 | 775,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -775,000.00 | -775,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 41,206,000.00 | 41,206,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -66,000.00 | -66,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 242,252,526.99 | 225,056,047.68 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 399,038.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 399,038.00 |
| 41300 | Өглөг | 0.00 | 399,038.00 |
| 41360 | Бусад өглөг | 0.00 | 399,038.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 399,038.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 242,252,526.99 | 224,657,009.68 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 242,252,526.99 | 224,657,009.68 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 135,912,688.00 | 135,912,688.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | -14,066,457.33 | -31,661,974.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -45,378,885.63 | -14,066,457.33 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 31,312,428.30 | -17,595,517.31 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 120,406,296.32 | 120,406,296.32 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 242,252,526.99 | 225,056,047.68 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **258,828,535.90** | **220,821,670.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 59,613,380.00 | 40,450,070.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 59,613,380.00 | 40,450,070.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 59,348,380.00 | 39,000,420.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 59,348,380.00 | 39,000,420.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 265,000.00 | 1,449,650.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 199,215,155.90 | 180,371,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 157,789,000.00 | 180,371,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 157,789,000.00 | 180,371,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 41,426,155.90 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 39,072,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,354,155.90 | |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **227,045,507.60** | **236,964,887.31** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 227,045,507.60 | 236,964,887.31 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 199,235,795.60 | 197,734,514.57 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 128,920,286.90 | 127,509,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 96,307,383.90 | 92,185,975.00 |
| 210102 | Нэмэгдэл | 27,945,329.00 | 29,152,033.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,667,574.00 | 6,171,892.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 17,418,869.00 | 17,213,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,971,869.00 | 12,113,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 635,200.00 | 1,275,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,016,500.00 | 1,020,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 254,100.00 | 255,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,541,200.00 | 2,550,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,610,900.00 | 12,524,599.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,282,856.71 | 8,941,505.26 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 2,098,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 328,043.29 | 1,484,494.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,089,302.00 | 6,978,833.67 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,284,700.00 | 1,145,005.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,884,400.00 | 2,467,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,324,750.00 | 2,111,330.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 201,200.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 951,956.00 | 424,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,442,296.00 | 831,498.67 |
| 2105 | Нормативт зардал | 1,000,000.00 | 1,230,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,000,000.00 | 1,230,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,812,100.00 | 340,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,812,100.00 | 340,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,500,000.00 | 5,770,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,500,000.00 | 5,770,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,767,428.00 | 922,932.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 400,000.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 378,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 189,500.00 | 189,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,000.00 | 78,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 20,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 49,368.00 | 32,912.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 30,000.00 | 24,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 642,560.00 | 578,520.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,116,909.70 | 25,243,749.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 363,714.00 | 3,612,972.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 398,725.00 | 1,920,340.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 16,354,470.70 | 19,710,437.64 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,809,712.00 | 39,230,372.74 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,440,300.00 | 35,097,838.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,842,300.00 | 33,577,838.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 598,000.00 | 1,520,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,369,412.00 | 4,132,534.74 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,369,412.00 | 4,132,534.74 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **31,783,028.30** | **-16,143,217.31** |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 470,600.00 | 1,452,300.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 470,600.00 | 1,452,300.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **31,312,428.30** | **-17,595,517.31** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 135,912,688.00 | 120,406,296.32 | -45,378,885.63 | 210,940,098.69 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 135,912,688.00 | 120,406,296.32 | -45,378,885.63 | 210,940,098.69 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 31,312,428.30 | 31,312,428.30 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 135,912,688.00 | 120,406,296.32 | -14,066,457.33 | 242,252,526.99 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 135,912,688.00 | 120,406,296.32 | -14,066,457.33 | 242,252,526.99 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 135,912,688.00 | 120,406,296.32 | -14,066,457.33 | 242,252,526.99 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -17,595,517.31 | -17,595,517.31 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 135,912,688.00 | 120,406,296.32 | -31,661,974.64 | 224,657,009.68 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **219,491,535.90** | **219,372,020.00** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 59,348,380.00 | 39,000,420.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 59,348,380.00 | 39,000,420.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 59,348,380.00 | 39,000,420.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 59,213,380.00 | 39,000,420.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 135,000.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 160,143,155.90 | 180,371,600.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 157,789,000.00 | 179,371,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 157,789,000.00 | 179,371,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,354,155.90 | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,354,155.90 | 1,000,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **213,414,635.90** | **218,772,020.00** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 213,414,635.90 | 218,772,020.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 185,552,923.90 | 179,940,685.26 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 128,920,286.90 | 127,509,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 96,307,383.90 | 92,185,975.00 |
| 210102 | Нэмэгдэл | 27,945,329.00 | 29,152,033.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,667,574.00 | 6,171,892.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 17,418,869.00 | 17,213,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,336,469.00 | 12,113,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,270,600.00 | 1,275,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,016,500.00 | 1,020,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 254,100.00 | 255,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,541,200.00 | 2,550,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 14,610,900.00 | 13,071,599.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,282,856.71 | 8,941,505.26 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 2,645,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 328,043.29 | 1,484,494.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,005,000.00 | 7,570,760.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 990,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,218,300.00 | 3,250,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,374,900.00 | 2,360,160.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 212,100.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 999,700.00 | 969,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,470,000.00 | 900,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,000,000.00 | 900,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 470,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,853,000.00 | 1,440,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800,000.00 | 640,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 800,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,500,000.00 | 5,770,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,500,000.00 | 5,770,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,774,868.00 | 864,412.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 400,000.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 378,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 189,500.00 | 189,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,000.00 | 78,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 20,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 49,368.00 | 32,912.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 30,000.00 | 24,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 650,000.00 | 520,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,000,000.00 | 5,599,514.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 4,800,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 799,514.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,861,712.00 | 38,831,334.74 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,492,300.00 | 34,698,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,842,300.00 | 33,178,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 650,000.00 | 1,520,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,369,412.00 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,369,412.00 | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 4,132,534.74 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 4,132,534.74 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **6,076,900.00** | **600,000.00** |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 6,076,900.00 | 600,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 6,076,900.00 | 600,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 6,076,900.00 | 600,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,076,900.00 | 600,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-6,076,900.00** | **-600,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 0.00 | 0.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **214,371,600.00** | **214,239,485.26** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 214,371,600.00 | 214,239,485.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 180,672,800.00 | 180,540,685.26 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 127,509,900.00 | 127,509,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 96,581,200.00 | 92,185,975.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26,968,700.00 | 29,152,033.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,960,000.00 | 6,171,892.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 17,213,800.00 | 17,213,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,113,400.00 | 12,113,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,275,100.00 | 1,275,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,020,100.00 | 1,020,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 255,000.00 | 255,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,550,200.00 | 2,550,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 13,072,600.00 | 13,071,599.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,100,000.00 | 8,941,505.26 |
| 210302 | Түлш, халаалт | 1,004,600.00 | 2,645,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,968,000.00 | 1,484,494.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7,574,300.00 | 7,570,760.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 990,000.00 | 990,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,250,900.00 | 3,250,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,363,700.00 | 2,360,160.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 169,700.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 800,000.00 | 969,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 900,000.00 | 900,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 900,000.00 | 900,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,440,000.00 | 1,440,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 640,000.00 | 640,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 800,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,770,700.00 | 5,770,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,770,700.00 | 5,770,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 991,500.00 | 864,412.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 189,500.00 | 189,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 78,000.00 | 78,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 20,000.00 | 20,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,000.00 | 32,912.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 24,000.00 | 24,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 520,000.00 | 520,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,200,000.00 | 6,199,514.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,400,000.00 | 5,400,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 800,000.00 | 799,514.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 33,698,800.00 | 33,698,800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,698,800.00 | 33,698,800.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 33,178,800.00 | 33,178,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 520,000.00 | 520,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **214,371,600.00** | **214,371,600.00** |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 179,371,600.00 | 175,371,180.00 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 179,371,600.00 | 175,371,180.00 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 35,000,000.00 | 39,000,420.00 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000,000.00 | 39,000,420.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 25.00 | 25.00 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 12.00 | 12.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 6.00 | 6.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,000,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,000,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,000,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд  шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт  2022 оны  01 дүгээр сарын 20-ны өдрийн  09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь “Хэмжил зүйн тухай” хуулийн 20.1-д заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Монгол Улсын Шадар Сайдын багцын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Орон нутгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тохирлын үнэлгээний,орон нутгийн нийгэм эдийн хөгжилд хэмжил зүйн бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлнэ*” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуульд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орж  2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд Стандарт хэмжил, зүйн газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэллээ.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 214.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.2 сая төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан бөгөөд өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | хувь |
|---|---|---|---|---|
| Бараа материал | 6.7 | 8.6 | 1.9 | 28.4 |
| Үндсэн хөрөнгө | 235.5 | 216.4 | (19.1) | (8.1) |
| **Нийт хөрөнгө** | 242.2 | 225.0 | (17.2) | (7.1) |
| Өр төлбөр | - | 0.4 | 0.4 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 242.2 | 224.6 | (17.6) | (7.3) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 242.2 | 225.0 | (17.2) | (7.1) |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 28.4 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 6.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 15.9 төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 1.4 сая төгрөг нийт 17.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 15.6 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 8.1 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 235.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 0.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 19.7 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 216.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр данс нь 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба энэ нь тэтгэвэрт гарсан ажилтны нэг удаагийн тэтгэмжийн өр байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 17.6 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой байна.

*Хүснэгт 2.* Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 157.8 | 179.4 | 21.6 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 2.3 | 1.0 | (1.3) |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 39.4 | 1.4 | (38.0) |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 59.3 | 39.0 | (20.3) |
| **Үйл ажиллагааны орлого** | **258.8** | **220.8** | **(38.0)** |
| Цалин, шимтгэлийн зардал | 146.3 | 144.7 | (1.6) |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 34.0 | 27.0 | (7.0) |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1.8 | 0.9 | (0.9) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 17.1 | 25.2 | 8.1 |
| Урсгал шилжүүлэг | 27.8 | 39.2 | 11.4 |
| **Үйл ажиллагааны зардал** | **227.0** | **237.0** | 10.0 |
| Үйл ажиллагааны бус зардал | 0.5 | **1.4** | 0.9 |
| **Үйл ажиллагааны үр дүн** | **31.3** | **(17.6)** | **(48.9)** |

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал санхүүжилт өмнөх оноос 21.6 сая төгрөг буюу 13.7 хувиар өссөн байна. Урсгал санхүүжилтээс 0.1 сая төгрөг , давсан орлогоос 4.0 сая төгрөг нийт 4.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 268.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 53.8 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 214.3 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 214.3 сая төгрөгийн төсөв батлагджээ.Гүйцэтгэлээр улсын төсвөөс 179.3 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 39.0 сая төгрөг нийт 218.3 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 214.2 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 4.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 0.1 сая төгрөгөөр хэмнэгдэж, төсөвт байгууллагын өөрийн орлого 4.0 сая төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 1.0 сая төгрөгийн санхүүжилт ирснийг аймгийн Засаг даргын А/756 дугаар захирамжаар “Чанарыг эрхэмлэгч” байгууллагын шагналд олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлангийн жилд тус байгууллагын дарга Г.Батбаатар нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрч ажлаас чөлөөлөгдөн, СХЗГ-ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 19-ны Б/85 дугаар тушаалаар даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Д.Хүрэлсүх томилогдон ажиллаж байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO/PAS 45005:2021 стандартыг төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, аймаг, сумын онцгой комисст танилцуулж, заавар зөвлөгөөг өгч ажилласан байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 214.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 214.2 сая төгрөгийг зарцуулж, 99.9 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь “Хэмжил зүйн тухай” хуульд заасны дагуу хэмжил зүйн ажил, үйлчилгээ үзүүлсний төлбөрийг төвлөрүүлдэг бөгөөд 2021 онд 35.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 39.0 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 111.4 хувиар давуулан биелүүлжээ.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
   - Байгууллагын дарга өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдсөнд нөхөх томилгоо хийж, 1.6 сая төгрөгийн цалин олгосон нь зайлшгүй шаардлагатай албан тушаалын томилгоо хийсэн байна.
   - Албан конторын тавилга, шагнал, албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: Ланд-80 маркийн 1993 онд үйлдвэрлэсэн 17.9 сая төгрөгийн анхны өртөг бүхий автомашинтай бөгөөд шатахууны зардалд 3.2 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 9.2 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Стандарт хэмжил, зүйн хэлтэс нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 145 мэдээллээс 121 мэдээллийг хугацаанд нь, 25 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүллээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын *“Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”* 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 7.2 % буюу 3.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул аудитаас зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.0 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төсөвт байгууллагын өөрийн орлогын гүйцэтгэлийг улсын төсөвт төвлөрүүлсэн 4.0 сая төгрөгөөр бууруулан тохируулга хийж, тайлагнасныг аудитын явцад залруууллаа.

4.2 Албан шаардлага

-Албан томилолтын зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад 159.0 мянган төгрөгийн томилолтын анхан шатны баримтын бүрдэл дутуу буюу томилолтоор ажилласан ажлын тайлан, илтгэх хуудасгүй, мөн байгууллагын дарга өөртөө томилолтын хуудсыг бичиж 53.0 мянган төгрөгийн томилолт авсан зэрэг нийт 212.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д" Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүллээ.

-----oOo-----

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | СХЗХ | 2 | 4.2 | 1 | 4.0 | 0 | 0 | 1 | 0.2 | 0 | 0 |
| Дүн | | 2 | 4.2 | 1 | 4.0 | 0 | 0 | 1 | 0.2 | 0 | 0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 2 | СХЗХ | 2 | 3.5 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 3.5 | 1 | 0 |
| Дүн | | 2 | 3.5 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 3.5 | 1 | 0 |
| Нийт дүн | | 4 | 7.7 | 1 | 4.0 | 0 | 0 | 2 | 3.7 | 1 | 0 |